



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/135/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70444470 Цахим хаяг: Аудитор: Ж.Байгалмаа Утас: 89966116 Цахим хаяг: Baigalmaa_bhr88@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал .....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15

Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.УУГАНБАЯР ТАНАА

2020.02.20 № 1/144

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020088

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал Б.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.18-наас 2020.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Ж.Байгалмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хонгорын үр сад аудит ХХК-ны газарт 2019.12.20-ны өдрийн 42 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сурах хүсэл сонирхолтой, бие даан суралцах чадвартай, эрүүл, зөв дадал хэвшилтэй, бусдыг ойлгож хүндэлдэг суралцагчийг төлөвшүүлнэ.” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, хүүхдийн хэрэгцээ сонирхлыг харгалзан адил тэгш оролцоог хангах
- Сургалтын алба, мэргэжлийн зөвлөлөөр хамтран ажлын байран дээр мэргэжил, заах арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх
- Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжлийн асуудлаар эцэг, эх, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан олон нийтийн оролцоот сургууль болох
- Насан туршийн боловсролын үйлчилгээг хамран сургах тойргийн иргэдэд хүртээмжтэй хүргэх гэсэн эрхэм зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolous программ хангамж ашигладаг байна.

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 548447,1 мянган төгрөгөөс тооцон 10968,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10968,9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15758,2 мянган төгрөгөөр буюу 0,8%-иар хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50076,8 мянган төгрөгөөр тус тус өссөн, бараа материалын дансны үлдэгдэл 3484,0 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,00	0,00	
Авлага	0	1789,3	1789,3
Урьдчилгаа	0,00	0,00	0,00
Бараа материал	28035,6	31519,6	3484,0
Үндсэн хөрөнгө	1028713,8	1078790,6	50076,8
Хуримтлагдсан элэгдэл	-315729,7	-355321,8	-39592,1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>741019,6</b>	<b>756777,8</b>	<b>15758,2</b>
Өр төлбөр	0,00	0,00	0,00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	741019,6	756777,8	15758,2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>741019,6</b>	<b>756777,8</b>	<b>15758,2</b>

Үндсэн хөрөнгийн 65934,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь төсвийн хөрөнгөөр 65934,7 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь сурагчдын сургалтын хэрэглэгдэхүүн, эм, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Хүрээмарал сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.03.29-ны өдрийн 07 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 15857,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд байхгүй, тайлант хугацаанд нэмж өр үүсээгүй, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх .12 хөтөлбөрт зориулан 554265,9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 554265,9 мянган төгрөгийг урсгал зардалд

зарцуулахаар батлагдсан ба үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 73786,0 мянган төгрөг батлагдаж 73820,0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нийт зардлын 509175,4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 45090,5 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 552434,3 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 1831,4 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв:** Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 3237,3 мянган төгрөг дансанд орсныг олгосон байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 6120,9–мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 5698,4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, биет бус хөрөнгийн ашиглалтыг сайжруулахтай холбоотой 422,6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 5698,4 мянган төгрөгийн залруулагдаагүй 2 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

- 1 Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтийн 1620,3 мянган төгрөгийг тайлант хугацааны эцэст Номин хөх ХХК бэлтгэн нийлүүлэгч байгууллагад илүү төлж авлагатай гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн зардлаас байгууллагын багш, ажилтан нарт даргын 2019.12.23-ны өдрийн 58 тоот тушаалаар 5120,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт”-ын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж заалтыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6		5
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	73	23	
	Нийт	27	151	117	29	5

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийн 8 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг эдгээр 3 мэдээг санамсаргүйн улмаас хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг-ийн 1-9 дүгээр сарын мэдээ мэдээллийг 2,3,4,8 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаа дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Биет бус хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тус байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгүүдийн ашиглалтын байдлыг судалж үзэхэд 200,0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ цахим архивд шилжсэнээр 222,6 мянган төгрөгийн бүртгэлтэй монгол бичгийн программ ашиглалтгүй байна.

1.2. Эрсдэл:  
Хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг гарахгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:  
Дээрх биет бус хөрөнгийг ашиглаж болох эсэхийг бусад эрх бүхий байгууллагад хандан дүгнэлт гаргуулж арга хэмжээ авч ажиллах.

### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

*Зөвшөөрсөн*

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,035,606.70	33,309,045.20
33	АВЛАГА	00.00	1,789,353.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	168,993.00
335	Бусад авлага	00.00	1,620,360.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,620,360.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,035,606.70	31,519,692.20
351	Түүхий эд материал	00.00	3,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	3,000,000.00
354	Хангамжийн материал	28,035,606.70	28,519,692.20
35410	Бичиг хэргийн материал	00.00	164,500.00
35420	Аж ахуйн материал	00.00	6,558,036.00
35440	Түлш, шатах тослох материал	3,539,100.00	237,100.00
35470	Бусад хангамжийн материал	24,496,506.70	21,560,056.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	712,984,060.22	723,468,819.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	712,984,060.22	723,468,819.32
392	Биет хөрөнгө	693,460,060.22	703,944,819.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	745,025,682.00	745,025,682.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-129,551,010.00	157,129,324.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,015,349.91	164,104,717.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-125,342,035.55	135,214,122.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,159,376.83	89,440,829.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,489,442.18	-40,956,949.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,741,537.12	46,741,537.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,724,691.51	-21,398,845.23
39217	Ном	10,625,293.60	13,331,293.60
393	Биет бус хөрөнгө	19,524,000.00	19,524,000.00
39301	Програм хангамж	622,600.00	622,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-622,600.00	-622,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,524,000.00	19,524,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	741,019,666.92	756,777,864.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	741,019,666.92	756,777,864.52
51	Засгийн газрын хувь оролцоо	741,019,666.92	756,777,864.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	290,170,245.35	290,170,245.35
51101	Өмч: - төрийн	290,170,245.35	290,170,245.35
512	Хуримтлагдсан үр дүн	-108,249,675.65	-92,491,478.05
51210	Өмнөх үеийн үр дүн	-108,249,675.65	-108,249,675.65

**Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,758,197.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	559,099,097.22	559,099,097.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	741,019,666.92	756,777,864.52

**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	413,335,504.00	564,205,309.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,857,500.00	9,256,409.80
120	Нийтлэг татварын бус орлого	3,857,500.00	9,256,409.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,857,500.00	9,256,409.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,357,500.00	9,256,409.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,478,004.00	554,948,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	406,556,400.00	509,175,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,313,600.00	683,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	683,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	45,090,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	45,090,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	443,352,291.64	548,338,315.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,352,291.64	548,338,315.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,045,718.64	534,194,154.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,330,422.00	339,671,843.00
210101	Үндсэн цалин	199,613,711.00	326,639,469.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,504,522.00	13,032,374.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,774,818.00	42,909,047.00
210201	Тэтгэврийн даатгал	22,137,288.00	29,360,646.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,877,229.00	3,455,994.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,054,599.00	2,736,633.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,045.00	668,706.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,186,657.00	6,687,068.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,312,522.00	40,500,733.00
210301	Гэрэл, цахилгаан	13,076,622.00	12,288,673.00
210302	Түлш, халаалт	27,196,900.00	28,212,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,074,425.75	11,666,266.50
210401	Бичиг хэрэг	644,000.00	1,703,350.00
210402	Тээвэр, шатахуун	2,601,050.00	3,392,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	563,280.00	1,081,346.00
210404	Ном, хэвлэл	00.00	627,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		

00.00 ТӨРИЙН 051,500.00  
005 ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,266,095.75	874,270.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,936,450.50
2105	Нормативт зардал	18,187,107.00	19,975,640.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,963.00	384,900.00
210502	Хоол, хүнс	18,025,144.00	19,290,740.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,425,500.00	16,808,715.00
210604	Урсгал засвар	2,425,500.00	16,808,715.00
2107	Томилолт, зочны зардал	734,000.00	2,696,200.00
210702	Дотоод албан томилолт	734,000.00	2,696,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,307,500.00	683,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,307,500.00	683,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,899,423.89	59,282,709.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	227,000.25	3,004,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,884,200.00	937,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,788,223.64	55,341,209.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,306,573.00	14,144,161.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,877,989.00	12,312,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	837,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,924,200.00	11,475,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	428,584.00	1,831,561.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	428,584.00	1,831,561.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-30,016,787.64	15,866,994.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	108,796.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	108,796.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-108,796.75
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-30,016,787.64	15,758,197.60

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	409,978,004.00	554,948,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,478,004.00	554,948,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,556,400.00	509,175,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,313,600.00	683,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	683,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	45,090,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	45,090,500.00

00.00
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
САНАЛ ДҮГНЭЛТ

**Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	409,978,004.00	498,270,544.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	409,978,004.00	498,270,544.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,105,116.00	483,801,986.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,609,705.00	341,941,300.00
210101	Үндсэн цалин	200,390,505.00	273,101,000.00
210102	Нэмэгдэл	28,578,800.00	20,790,900.00
210104	Урамшуулал	18,400,800.00	30,634,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,239,600.00	17,415,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,437,600.00	40,742,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,043,200.00	27,273,618.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,598,400.00	3,361,723.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,078,400.00	2,692,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	520,000.00	676,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,197,600.00	6,739,059.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,361,222.00	37,198,733.00
210301	Гэрэл, цахилгаан	13,076,622.00	12,288,673.00
210302	Түлш, халаалт	28,245,600.00	24,910,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,325,166.00	7,177,452.00
210401	Бичиг хэрэг	488,500.00	1,090,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,540,950.00	2,789,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	293,700.00	1,284,116.00
210404	Ном, хэвлэл	324,100.00	992,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	78,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	677,916.00	941,836.00
2105	Нормативт зардал	18,645,523.00	21,949,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,963.00	384,900.00
210502	Хоол, хүнс	18,054,560.00	20,911,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	429,000.00	653,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,155,300.00	20,784,715.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,800,000.00
210604	Урсгал засвар	1,155,300.00	15,984,715.00
2107	Томилолт, зочны зардал	734,000.00	2,696,200.00
210702	Дотоод албан томилолт	734,000.00	2,696,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,522,600.00	773,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,522,600.00	773,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,314,000.00	10,538,686.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,634,400.00	7,062,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,679,600.00	3,476,486.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,872,888.00	14,468,558.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,444,304.00	12,636,997.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,954,000.00	11,475,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000.00	1,161,397.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	439,794.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	439,794.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,391,767.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,391,767.00

**Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	56,678,356.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	56,678,356.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	56,678,356.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	56,678,356.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	56,678,356.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-56,678,356.00

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцсоний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-108,249,675.65	00.00	741,019,666.92
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-108,249,675.65	00.00	741,019,666.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-108,249,675.65	00.00	741,019,666.92
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,758,197.60	00.00	15,758,197.60
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,170,245.35	559,099,097.22	-92,491,478.05	00.00	756,777,864.52

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	407,056,400.00	406,627,816.00	554,265,900.00	552,434,339.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,056,400.00	406,627,816.00	554,265,900.00	552,434,339.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,210,600.00	371,791,516.00	541,504,500.00	539,797,342.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,907,400.00	265,609,705.00	341,941,300.00	341,941,300.00
210101	Үндсэн цалин	200,688,200.00	200,390,505.00	273,101,000.00	273,101,000.00
210102	Нэмэгдэл	28,578,800.00	28,578,800.00	20,790,900.00	20,790,900.00
210104	Урамшуулал	18,400,800.00	18,400,800.00	30,634,400.00	30,634,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,239,600.00	18,239,600.00	17,415,000.00	17,415,000.00

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,508,900.00	32,437,600.00	40,742,700.00	40,742,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,090,800.00	22,043,200.00	27,269,400.00	27,269,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,604,800.00	2,598,400.00	3,368,300.00	3,368,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,083,300.00	2,078,400.00	2,694,700.00	2,694,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	520,900.00	520,000.00	673,600.00	673,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,209,100.00	5,197,600.00	6,736,700.00	6,736,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,363,500.00	41,361,222.00	38,590,500.00	37,198,733.00
210301	Гэрэл, цахилгаан	12,295,800.00	13,076,622.00	12,295,800.00	12,288,673.00
210302	Түлш, халаалт	28,881,200.00	28,245,600.00	25,594,700.00	24,910,060.00
210303	Цэвэр, бохир ус	186,500.00	39,000.00	700,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,335,000.00	4,325,166.00	9,672,600.00	9,583,452.00
210401	Бичиг хэрэг	488,500.00	488,500.00	1,054,200.00	1,090,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,542,000.00	2,540,950.00	2,742,000.00	2,789,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	293,700.00	293,700.00	1,940,600.00	1,284,116.00
210404	Ном, хэвлэл	369,300.00	324,100.00	2,796,800.00	3,398,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	78,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	641,500.00	677,916.00	959,000.00	941,836.00
2105	Нормативт зардал	18,645,600.00	18,645,523.00	22,025,700.00	21,949,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	162,000.00	161,963.00	317,600.00	384,900.00
210502	Хоол, хүнс	18,054,600.00	18,054,560.00	21,000,900.00	20,911,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	429,000.00	429,000.00	707,200.00	653,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,155,300.00	1,155,300.00	73,786,000.00	73,820,071.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	10,000,000.00	10,000,000.00
210602	Тавилга	00.00	00.00	22,250,000.00	22,249,000.00
210604	Урсгал засвар	1,155,300.00	1,155,300.00	41,536,000.00	41,571,071.00
2107	Томилолт, зочны зардал	743,400.00	734,000.00	2,696,200.00	2,696,200.00
210702	Дотоод албан томилолт	743,400.00	734,000.00	2,696,200.00	2,696,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,000.00	209,000.00	271,000.00	90,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,000.00	209,000.00	271,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7342500.00	7314000.00	11778500.00	11775686.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,634,400.00	1,634,400.00	8,000,000.00	7,999,200.00

**Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,708,100.00	5,679,600.00	3,778,500.00	3,776,486.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34845800.00	34836300.00	12761400.00	12636997.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,845,800.00	34,836,300.00	12,761,400.00	12,636,997.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,954,000.00	10,954,000.00	11,600,000.00	11,475,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	449,500.00	440,000.00	1,161,400.00	1,161,397.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>407,056,400.00</b>	<b>406,627,816.00</b>	<b>554,265,900.00</b>	<b>552,434,339.00</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	406,556,400.00	406,127,816.00	509,175,400.00	508,735,606.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,556,400.00	406,127,816.00	509,175,400.00	508,735,606.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	45,090,500.00	43,698,733.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	45,090,500.00	43,698,733.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	36.00	38.00	37.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	19.00	21.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	16.00	16.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.00	35.00	38.00	37.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21.00	19.00	21.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	11.00	11.00
650010	Гэрээт ажилтан	06.00	06.00	06.00	06.00

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		683000
21	УРСГАЛ ЗАРДАЛ		683000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		683000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		683000



Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		683000	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ж.БАЙГАЛМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

